

LEGAL NEWSLETTER

First Quarter 2026

№61

AKP Law Firm

Бид 2026 оны 1-р улиралд батлагдсан онцлох Засгийн Газрын тогтоол болон энэ улиралд гарсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоолыг танилцуулж байна.

I. ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСӨЛ:

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд татварын орчныг олон улсын стандартад нийцүүлэх, цахим шилжилтийг сайжруулах зорилгоор **татварын багц хуульд** томоохон нэмэлт, өөрчлөлтүүд орохоор хүлээгдэж байсан бөгөөд төслийн зорилго нь татвар төлөгчийн ачааллыг бууруулах, зөвлөн туслах үйлчилгээг нэмэгдүүлэхэд чиглэж байсан.

Гэсэн хэдий ч Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг татан авах тухай албан бичгийг 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд хүргүүлсэн байна.

Энэ талаар Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт танилцуулжээ.

II. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

2026 оны 1 дүгээр улиралд нийт 54 Засгийн газрын тогтоол батлагдсан ба тэдгээрээс дараах тогтоолуудыг онцолж байна.

2.1. УЛСЫН ХИЛИЙН ЗУРВАСТ ГАЗАР АШИГЛУУЛАХ ТУХАЙ ТОГТООЛЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ (Засгийн газрын 51 дүгээр тогтоол)

Засгийн газрын 2026 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хилийн 10 боомтын

орчимд 34,227 га газар ашиглуулахаар шийдвэрлэсэн өмнөх тогтоолуудыг (2025 оны 262 болон 09 дүгээр тогтоол) хүчингүй болгож, "Боомтын хөгжлийн корпорац" ТӨХХК-тай байгуулсан газар ашиглах гэрээг цуцаллаа.

Уг шийдвэрийг гаргахдаа хилийн халдашгүй дархан байдлыг хангах, газар олголтын явцад хууль зөрчсөн болон ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй гэж үзсэн байна. Иймд холбогдох газрын солбицол, талбайн хэмжээг Газрын нэгдмэл сангийн удирдлагын системд буцаан бүртгэхийг үүрэг болгожээ.

2.2. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ТАЛБАЙН СОЛБИЦЛЫГ БАТЛАХ, ЭРХ ОЛГОХ ТУХАЙ (Засгийн газрын 29 дүгээр тогтоол)

Засгийн газрын 2026 оны 29 дүгээр тогтоолоор "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал (элс, хайрга, дайрга) хайх, ашиглах талбайн солбицлыг баталлаа.

Уг шийдвэрээр төсөл гүйцэтгэгч хуулийн этгээдэд ашиглалтын зөвшөөрөл олгох, нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх болон ашигласан талбайн нөхөн сэргээлтэд хяналт тавьж ажиллахыг Өмнөговь аймгийн Засаг даргад үүрэг болгосон байна. Энэхүү тогтоол нь бүтээн байгуулалтын ажлыг түүхий эдээр тасралтгүй хангах, байгаль орчныг хамгаалах зорилготой юм.

2.3. СТРАТЕГИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ГАДААД АЖИЛТНУУДЫГ ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ (Засгийн газрын 68 дүгээр тогтоол)

Засгийн газрын 2026 оны 68 дугаар тогтоолоор Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж буй стратегийн ач холбогдолтой дэд бүтэц, үйлдвэрлэл, шинэ хотын бүтээн байгуулалтын төслүүдийг дэмжих шийдвэр гаргалаа. Уг тогтоолын хүрээнд гадаадын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй 17 аж ахуйн нэгжийн нийт 8,205 гадаад

ажилтныг 2026 оныг дуустал ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөөр болов.

Энэхүү чөлөөлөлтөд эрчим хүч, тээвэр болон хүнд үйлдвэрлэлийн томоохон төслүүд голлон багтсан байна. Тухайлбал:

- **Дэд бүтэц, зам тээвэр:** "Гашуунсухайт-Ганцмод" боомтын төмөр зам (1280 ажилтан) зэрэг нийслэлийн түгжрэл болон экспортын гарцыг нэмэгдүүлэх төслүүд.
- **Эрчим хүч:** Нийслэлийн дулаан, цахилгааны хангамжийг нэмэгдүүлэх "ДЦС-5" (1600 ажилтан) болон бүсийн эрчим хүчний бие даасан байдлыг хангах "Эрдэнэбүрэнгийн УЦС" (100 ажилтан).
- **Уул уурхай, үйлдвэрлэл:** "Цагаан суваргын баяжуулах үйлдвэр" (950 ажилтан) болон "Болдтөмөр ерөө гол" компанийн кокс, ширэмний үйлдвэрүүд (750 ажилтан).

Мөн "Газопровод Союз Восток" ХХК-ийн байгалийн хийн хоолойн зураг төслийн баг багтсан нь бүс нутгийн дамжин өнгөрөх тээврийн стратегийг дэмжсэн хэрэг юм. Эдгээр аж ахуйн нэгжүүдийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлснөөр томоохон бүтээн байгуулалтууд төлөвлөсөн хугацаандаа, эдийн засгийн үр ашигтай хэрэгжих боломж бүрдэж байна.

2.4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ТУХАЙ (Засгийн газрын 71 дүгээр тогтоол)

Засгийн газрын 71 дүгээр тогтоолоор иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, олон улсын аудитын шалгалтад бэлтгэх хүрээнд Сайншанд хотод "Нислэгийн хөдөлгөөний удирдлагын нөөц төв"-ийн барилгыг 2026 оны II улиралд эхлүүлэхээр шийдвэрлэлээ.

Мөн салбарын хяналт, зохицуулалтын чиг үүргийг бэхжүүлэх зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 117 болгон нэмэгдүүлж, бүтцийн оновчлол хийхийг даалгасан байна.

III. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ:

2026 оны эхний улирлын байдлаар (1-3 дугаар сар) Үндсэн хуулийн цэцээс нийт 3 тогтоол гаргасан байна. Эдгээрээс эрх зүйн ач холбогдол болон хяналт-тэнцвэрийн зарчмыг бататгасан дараах шийдвэрийг онцолж байна.

3.1. СОНСГОЛ ЯВУУЛАХ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ (01 дүгээр тогтоол)

Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сард хууль батлахдаа, өмнө нь Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн хэмээн хүчингүй болгож байсан "Цэцийн гишүүн болон шүүгч, прокурорт нэр дэвшигчид томилгооны сонсгол явуулах" заалтыг агуулгаар нь дахин сэргээж баталсан байна.

Цэцийн Их суудлын хуралдаанаар уг үйлдлийг хууль дээдлэх болон Цэцийн шийдвэр эцсийн байх суурь зарчмыг зөрчсөн гэж үзэж, холбогдох заалтуудыг эцэслэн хүчингүй болгожээ.

3.1.1. ХҮЧИНГҮЙ БОЛСОН ХУУЛИЙН ЗААЛТУУД

Дээрх тогтоолын дагуу Улсын Их Хурлын баталсан дараах хуулийн заалтууд шууд хүчингүй болсон байна. Үүнд:

- **УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль:** Цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор зэрэг албан тушаалтанд нэр дэвшигчдэд УИХ дээр томилгооны сонсгол явуулах тухай заалтууд (30.1.1, 30.1.2 дахь заалт).
- **УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль:** Нэр дэвшигчийн сонсголын тайлан гаргах, түүнийг хэлэлцэж санал дүгнэлтэд тусгахтай холбоотой процессын зохицуулалтууд (104.1 дэх хэсэг).

3.1.2. ШИЙДВЭРИЙН ОНЦЛОГ

Шүүгч, Цэцийн гишүүнийг томилохын өмнө УИХ дээр нээлттэй сонсгол явуулах нь тэднийг улс төрийн нөлөөнд оруулах, хараат бус байдалд нь халдсан хэрэг гэж Цэц дүгнэсэн. Түүнчлэн, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болдог бөгөөд хууль тогтоох байгууллага хүчингүй болсон заалтыг "шинэчилсэн найруулга" зэрэг хэлбэрээр дахин сэргээх эрхгүй гэдгийг энэхүү тогтоолоор баталгаажуулсан нь төрийн эрх мэдэл хуваарилалтын хяналт-тэнцвэрийг хадгалсан чухал онцлогтой юм.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
3-р хороо, Pearl tower A блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8013-0414